



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Монголын социал демократ намын дүрэм
/Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын социал демократ намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын социал демократ намын дарга А.Ганбаатараас "... намын Их хурлаараа баталсан дүрэм, мөрийн хөтөлбөрийг бүртгэж авна уу" гэсэн өргөдлийг нийт 75 хуудас баримт, 1 ширхэг флашийн хамт 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр, нэмэлтээр 17 хуудас баримтыг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улсын дээд шүүхэд тус тус ирүүлсэн.

Дээрх өргөдөл болон түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, сонсох ажиллагааг хийсэн ба тухайн ажиллагааны явцад 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр 70 хуудас баримт, 1 ширхэг флашийг нэмэлтээр ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд "Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ" гэж заасан хугацаанд буюу 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монголын социал демократ намаас "шинэчлэн баталсан намын дүрмийг бүртгүүлэх" өргөдлийг гаргаж байсан

бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын хувьд зөрчилтэй, намын шинэчилсэн дүрмийн зарим заалтууд хуульд нийцээгүй, хуульд зааснаар дүрэмд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулсан” үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Тус тогтоолын Тогтоох хэсгийн 2 дахь заалтаар гардаж авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор намын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх өргөдлийг дахин нэг удаа ирүүлэхийг мэдэгдсэний дагуу Монголын социал демократ нам нь 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр ээлжит бус Их хурлаа хуралдуулан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ээ баталж, бүртгүүлэх өргөдлийг тогтоосон хугацаанд буюу 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын дээд шүүхэд дахин гаргасан, улмаар Улсын дээд шүүхээс явуулсан сонсох ажиллагааны дараа 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ээлжит бус Их хурлыг дахин хуралдуулж, дээрх дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулан, Улсын дээд шүүхийн тогтоолд заасан зөрчлийг арилгаж, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан шаардлагад нийцүүлсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Монголын социал демократ намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр болон 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр тус тус хуралдсан намын ээлжит бус Их хурлын тухайд:

1.1. Монголын социал демократ намын дүрэм (2008 он)-ийн 9 дүгээр зүйлийн 2-т “Намын Их хурлын товыг намын Улс төрийн зөвлөлөөс зарлана”, 11 дүгээр зүйлд “Аливаа шатны намын зөвлөлийн хурал, түүнийг сонгох эрх бүхий хурал, мөн Хянах зөвлөлийн хурал, намын Их хурал энэ дүрмээр олгогдсон эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргахдаа дор дурдсан заалтыг удирдлага болгоно”, 11 дүгээр зүйлийн 3-т “Энэ дүрэмд өөрөөр заагаагүй тохиолдолд шийдвэрийг хуралд таслах эрхтэй оролцогсдын 50-аас дээш хувийн саналаар гаргана”, 4-т “Аливаа шатны намын зөвлөлийн хурал нь бүх гишүүдийн 50-аас дээш хувь оролцсон нөхцөлд хүчинтэй” гэж зохицуулжээ.

Монголын социал демократ намын Улс төрийн зөвлөл нь 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр нийт 21 гишүүний 50-аас дээш буюу 66.6 хувийн ирцтэйгээр хуралдан, намын ээлжит бус Их хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, “Намын Их хурлыг зарлан хуралдуулах тухай” 26/04-УТЗТ тогтоолыг батлан, Их хуралд сонгогдон оролцох төлөөлөгчдийн нэрсийг бүрдүүлэн ирүүлэхийг Нийслэлийн намын зөвлөлд даалгаж шийдвэрлэсэн байна.

Тус шийдвэрийг гаргасан намын төлөөллийн төв байгууллага болох Улс төрийн зөвлөлийн бүрэлдэхүүний тухайд, 2008 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хуралдсан намын анхдугаар Их хурлын 5 дугаар тогтоолоор нийт 31 гишүүнтэй байхаар сонгож баталсан байх ба Улс төрийн зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн №21/07-УТЗТ, 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 24/06-УТЗТ дугаартай тогтоолоор тус тус зарим төлөөлөгчдийг чөлөөлж, мөн нөхөн сонгож, нийт 21 гишүүнтэй болсныг тус тус батламжилсан баримтыг ирүүлжээ. Ийнхүү гишүүдийг

нөхөн сонгож, өөрчилсөн нь намын дүрмийн 8 дугаар зүйлийн 3-т “Дор дурдсан заалт нь аливаа шатны намын зөвлөлд хамаарна”, II) “Зөвлөлийн гишүүнийг өөрийнх нь хүсэлт, намын хянах зөвлөл буюу шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн зөвлөл эсвэл сонгогдсон хурал нь чөлөөлж, мөн нөхөн сонгож болно” гэж заасанд нийцсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 20 дугаар тогтоолд заасан “... 2008 оны анхдугаар Их хурлаар Улс төрийн зөвлөлийн 31 гишүүнийг баталж, үүнээс хойш тус бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан мэдээлэл байхгүй тул ... 16-аас дээш гишүүн оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр байх атал энэ шаардлага хангагдаагүй” гэх зөрчил арилсан байна.

Намын дүрэм (2008)-ийн 18 дугаар зүйлийн 1-д “Намын Их хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг дор дурдсан байдлаар бүрдүүлнэ”, “1.1. Доод шатны хурлаас сонгогдсон төлөөлөгчид; 1.2. Улс төрийн зөвлөлийн гишүүд, Хянах зөвлөлийн гишүүд” гэж заасан тул дүрмийн 1.2-т заасан сонгуульт гишүүд болон Нийслэлийн намын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 26/01-НЗТ тогтоолоор сонгогдсон 20 төлөөлөгчийн хамт ээлжит бус Их хурлын нийт 43 төлөөлөгчийг сонгож, 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 4(7) дугаар ээлжит бус Их хурлын Мандатын комиссын 03 дугаар тогтоол, Тооллогын комиссын 04 дүгээр тогтоолоор ээлжит бус Их хуралд хүрэлцэн ирсэн 31 төлөөлөгчдийн 100 хувийн саналаар ээлжит бус Их хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулсан байна.

Монголын социал демократ намын дүрэм (2008 он)-д ээлжит бус Их хурлыг хуралдуулахаас өмнө товлон зарлах тодорхой хугацааг заагаагүй бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдах ээлжит бус 4(7) дугаар Их хурлын зарыг төлөөлөгчдөд 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр гар утасны дугаараар зурвас бичиж хүргэсэн талаарх баримтыг ирүүлсэн байна. Их хуралд сонгогдсон нийт 43 төлөөлөгчөөс 31 нь биечлэн оролцож, намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг 100 хувийн саналаар дэмжин баталсан нь тус Их хурлын “Намын дүрэм шинэчлэн батлах тухай” №26/01-ИХТ дүгээр тогтоол, Редакцын комиссын 05 дугаар тогтоол, хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл, намын гишүүний үнэмлэх, хурлын тов мэдэгдсэн зурвасын хуулга болон баримтаар ирүүлсэн дуу болон дүрс бичлэг, фото зургаар тогтоогдож байна.

1.2. Монголын социал демократ намын 4(7) дугаар ээлжит бус Их хурлаар хэлэлцэн баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдлийг шалгах ажиллагааны явцад дүрмийн зарим зохицуулалтыг тодруулах зорилгоор 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын дээд шүүхийн Бүртгэлийн албанаас сонсох ажиллагааг зохион байгуулсан. Тус ажиллагааны явцад хэлэлцэгдсэн асуудалтай холбогдуулан Монголын социал демократ нам нь 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ээлжит бус 5(8) дугаар Их хурлыг зарлан хуралдуулж, 4(7) дугаар Их хурлаар баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байх ба тухайн Их хурлаар баталсан дүрмийг, хурлыг хуралдуулсан баримтын хамт Улсын дээд шүүхэд нэмж ирүүлсэн.

Улс төрийн зөвлөл нь 58 хувийн ирцтэйгээр, 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, намын ээлжит бус 5(8) дугаар Их хурлыг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахаар товлж, УТЗТ-26/004 дүгээр тогтоолыг баталсан

бөгөөд намын дүрэм (2008 он)-ийн 18 дугаар зүйлд заасны дагуу ээлжит бус 5(8) дугаар Их хуралд оролцохоор нийт 44 төлөөлөгч сонгогдсон байна.

Намын ээлжит бус 5(8) дугаар Их хуралд нийт сонгогдсон төлөөлөгчдийн 70.7 хувь буюу 30 төлөөлөгч биечлэн оролцож, эдгээр төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжин, “Намын дүрэм шинэчлэн батлах тухай” 26/01-ИХТ тогтоолыг баталсан нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “... Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, ...”, намын дүрэм (2008 он)-ийн 9 дүгээр зүйлийн 3-т “Дор дурдсан эрхийг зөвхөн намын Их хурал эдэлнэ”, 1) “Намын чиг баримтлал, дүрмийг батлах” гэж заасанд нийцсэн байх бөгөөд тухайн ээлжит бус Их хурлыг товлон зарласан болон хуралдааны үйл ажиллагаа, шийдвэр нь намын дүрмийн дагуу, аливаа зөрчилгүйгээр явагдсан болох нь өргөдөлд баримтаар ирүүлсэн Улс төрийн зөвлөл болон ээлжит бус Их хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, фото зураг, дуу болон дүрсний бичлэгээр тогтоогдож байна.

Хоёр. Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн тухайд:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан тус намын ээлжит бус 3(6) дугаар Их хурлын 01 дүгээр тогтоолоор баталсан намын дүрмийн зарим заалтууд хуульд нийцээгүй, хуульд зааснаар дүрэмд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулсан, тухайлбал, төрийн байгууллагын удирдлагад намаас нэр дэвшин томилогдсон буюу төрийн байгууллагын сонгуульд намаас нэр дэвшсэн үедээ намаас зохих ёсны дэмжлэг авах”-аар заасан нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т нийцэхгүй; хяналтын байгууллагын үйл ажиллагаанд төлөөллийн төв байгууллага оролцож, эрх хэмжээг нь давхар хэрэгжүүлж байгаа нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3-т заасан шаардлагыг хангаагүй; намын гишүүнээс хасах болон сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болон сахилгын шийтгэлийн төрлийг тодорхой бусаар нэгтгэн заасан, намын бүтцийн байгууллагыг байгуулахад хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан шаардлага хэрхэн хангагдах нь тодорхойгүй; тус намын гүйцэтгэх байгууллага нь Тамгын газар мөн эсэх, энэ тохиолдолд тухайн бүтцийн байгууллагыг хаанаас хэрхэн томилох, хугацаа, үндэслэл, журмыг намын дүрмээр тодорхой зохицуулаагүй; намын бүтцийн байгууллагад аль нэг хүйсийн төлөөллийг нэр дэвшүүлэхэд 30 хувиас доошгүй байх, харин бүрэлдэхүүнд 40 хувиас доошгүй байх, төлөөллийн, хяналтын, гүйцэтгэх байгууллагын гишүүд хугацаанаасаа өмнө чөлөөлөгдөх тохиолдолд нөхөн болон шийдвэр гаргах, үндэслэл, журмын талаар намын дүрэмд тодорхой тусгаагүй; намын мөрийн хөтөлбөрийг батлах эрхийг намын төлөөллийн төв байгууллагад олгосон нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д нийцээгүй; гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэхтэй холбоотой журмыг тодорхой тусгаагүй; намд олгох төрийн санхүүжилтийг хуульд заасан зорилгоор болон салбар, бүтцийн нэгжид хуваарилах шалгуур, нөхцөл, хувь хэмжээ, энэ талаар шийдвэр гаргах эрх хэмжээ, процессыг намын дүрмээр зохицуулаагүй; намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам тодорхойгүй зэрэг алдаа зөрчлийг дурдаж, буцаасан.

Монголын социал демократ намын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит бус 4(7) дугаар Их хурлаар намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, улмаар 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус 5(8) дугаар Их хурлаар тус дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд, төлөөлөгчдийн 100 хувийн саналаар баталсан нь 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит бус Их хурлын №26/01-ИХТ дугаар тогтоол, Редакцын комиссын 05 дугаар тогтоол болон 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус Их хурлын ИХТ-26/01 дугаартай тогтоол, Редакцын комиссын 03 дугаар тогтоол, эдгээр хурлын тэмдэглэлүүд, фото зураг, дуу, дүрс бичлэг болон бусад бичгийн баримтаар тогтоогдож байх бөгөөд Улсын дээд шүүхийн тогтоолд заасан дээрх зөрчлийг дараах байдлаар зассан байна. Тухайлбал,

Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд төлөөллийн төв байгууллага оролцож, эрх хэмжээг нь давхар хэрэгжүүлэхээр заасан байсныг намын дүрмийн 3.1-д “Хянах зөвлөл намын гишүүнээс хасах, түдгэлзүүлэх бусад сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэх эрх бүхий хараат бус байгууллага байна”, 3.7-д “Хянах зөвлөлийн үйл ажиллагааны болон маргааныг хянан шийдвэрлэх журмыг намын Их хурал батална” гэж;

Намын дүрмийн 3.2-т намын гишүүнээс хасах үндэслэлийг зааж, тэдгээр үндэслэлийн агуулгыг 3.2.1, 3.2.2-т тодорхойлон тусгасан, харин 3.3-т сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, сахилгын шийтгэлийн төрлийг 3.4-т тус тус зохицуулан “намын дүрэмд тодорхой тусгах шаардлагатай” гэж үзсэн зөрчлийг арилгасан;

Намын дүрмийн 11.1-д “Бүх шатны намын зөвлөлийн хурал, түүнийг сонгох эрх бүхий хурал, мөн Хянах зөвлөлийн хурал, намын Их хурал, Тамгын газрын хурал нь энэ дүрмээр олгогдсон эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргахдаа дор дурдсан заалтыг удирдлага болгоно. Үүнд: 11.1.2.Хүнтэй холбогдсон ээдрээтэй асуудлыг нууц санал хураалтаар, бусад асуудлыг ил санал хураах замаар шийдвэрлэнэ” гэж намын бүтцийн байгууллагыг байгуулахад тавигдах Улс төрийн намын тухай хууль, /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан шаардлагыг нэмж тусгасан;

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.2.3-т зааснаар бүтцийн байгууллагуудыг бүрдүүлэхээр нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх, 17 дугаар зүйлийн 17.7-д заасан төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх шаардлагыг намын дүрмийн 7.3-т “МСДН-ын байнгын удирдах байгууллагуудад аль нэг хүйсийн төлөөллийг нэр дэвшүүлэхэд 30 хувиас доошгүй байх, харин бүрэлдэхүүнд 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна” гэж нэмж зохицуулсан;

Намын гүйцэтгэх төв байгууллагыг дүрмийн 15.1-д “МСДН-ын Тамгын газар нь намын гүйцэтгэх төв байгууллага бөгөөд бөгөөд Улс төрийн зөвлөлийн шийдвэрээр байгуулагдан намын дүрэм, бодлого, шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ”, 15.2-т “Улс төрийн зөвлөл нь Тамгын газрын бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар, 4 жилийн хугацаагаар сонгож батална” гэж Улс төрийн намын тухай хууль, /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.5-

д “... намын удирдах байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно” гэсэн заалтад нийцүүлэн тодорхой зохицуулсан;

Намын дүрмийн 8.4.2-т “Зөвлөлийн гишүүн хүсэлтээ өгснөөр чөлөөлөгдөж болно. Харин Улс төрийн зөвлөл болон Хянах зөвлөлийн гишүүнийг хугацааны өмнө нөхөн сонгох асуудлыг Их хурлаар шийдвэрлэнэ. Тамгын газрын гишүүнийг хугацааны өмнө нөхөн сонгох асуудлыг Улс төрийн зөвлөл шийдвэрлэнэ” гэж Улс төрийн намын тухай хууль, /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 17.2.2-т намын төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг ... сонгох, ... хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг ... сонгох” гэж заасанд болон 17 дугаар зүйлийн 17.5-д нийцүүлэн өөрчилсөн;

Түүнчлэн, намын дүрэмд тусгах шаардлагатай зохицуулалтыг тодорхой тусгаагүй зөрчилтэй байсан намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг болон намын дотоод аудиторыг нэр дэвшүүлэх, сонгох, нөхөн томилох журмыг, намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг дүрмийн 15, 21 дүгээр зүйлд нэмж тодорхой зохицуулсан;

Намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах нөхцөл, шаардлага, намын даргад нэр дэвшүүлэх болзол, шаардлага болон шийдвэрлэх эрх бүхий этгээдийг намын дүрмийн 8.2, 16 дугаар зүйлд намын дүрэмд тусгасан;

Намын дүрмийн 14.5-д хуульд нийцэхгүй зохицуулалт байсныг хасаж, дүрмийн 14.6-д “Намын мөрийн хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар УТЗ-ийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргасан тохиолдолд өөрчлөлт оруулахыг зөвхөн намын Их хурал шийдвэрлэнэ”, 14.7-д “Намын УТЗ-ийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж өөрчлөн, хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.4-т заасан агуулга, шаардлагад нийцүүлсэн;

Намын гишүүн болон сонгуульт гишүүний татварын хэмжээг хуульд нийцүүлэн Улс төрийн зөвлөл буюу төлөөллийн төв байгууллага тогтоох зохицуулалт, гишүүнийг татвараас чөлөөлөх, хөнгөлөх үндэслэл, журмыг намын дүрэм болон холбогдох Төлөөллийн төв байгууллагаас баталсан журмаар тогтоохоор дүрэмд нэмж тусгасан;

Намын бүх орлого, хандивыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах, цахим мөнгөөр хүлээн авах болон намаас аль ч сонгуульд нэр дэвших эрх олгохдоо гишүүн, дэмжигчээс барьцаа, дэнчин болон бусад хэлбэрээр мөнгө, мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ авахыг хориглох, намд жил бүр олгох төрийн санхүүжилтийг тодорхой зориулалт, хувь хэмжээгээр зарцуулах, хуваарилах талаар намын дүрэмд тусгаж, хуульд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

Дээрх байдлаас үзэхэд, Монголын социал демократ намын дүрэм нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.10-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байх тул Монголын социал демократ

намын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцсэн байна.

Иймд, Монголын социал демократ намын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит бус 4(7) дугаар Их хурлын 26/01-ИХТ дугаар тогтоолоор баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/, түүнд 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус 5(8) дугаар Их хурлын ИХТ-26/01 дүгээр тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил байхгүй тул намын дүрмийг бүхэлд нь бүртгэхээр тогтов.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсгийг баримтлан Монголын социал демократ намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ